

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ХОЙД БҮС ДЭХ
ГАЗРЫН 2019 ОНЫ 08 ДУГААР САРЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН
/2019.07.26-2019.08.25/

2019 оны 08 дугаар сарын 25

Сүхбаатар сум

Гадаадын иргэн, харьяатын газрын Хойд бүс дэх газрын 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрөөс 2019 оны 08 дугаар сарын 25-ны өдрийг дуусталх хугацаанд Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль, Харьяатын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль, Монгол улсын хилийн тухай хууль, Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоол, 2018 оны 145,146 дугаар тогтоолоор батлагдсан журмууд болон Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, 2019 оны А/75 дугаар тушаалаар баталсан “Орон нутагт дахь газрын ажиллах журам”, “Ажил үйлчилгээний стандарт”-ыг үйл ажиллагаандаа удирдлага болгон ажиллаж төрийн үйлчилгээг өөрийн орны болон гадаадын иргэдэд түргэн шуурхай, чирэгдэлгүй хүргэн, төрийн албыг зохих түвшинд зохион байгуулан ажиллаж байна.

2019 оны 08 дугаар сард хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гарган газрын даргаар батлуулан, төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

НЭГ: Сургалт, хурал зөвлөгөө

Тус газраас зохион байгуулсан 1 удаагийн хамт олны хурал, 1 удаагийн зөвлөлийн хурлыг зохион байгуулж цаг үеийн байдлын талаар тодорхой үүрэг чиглэл авч ажилласан.

ХОЁР: Хүний нөөцийн талаар

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам”, 2019 оны А/75 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутаг дахь газрын ажиллах журам”, “Байгууллагын албан хаагчдын ёс зүйн дүрэм”, “Байгууллагын ажил үйлчилгээний стандарт”, “Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт” болон бусад хууль, тогтоомжийг ажил үүрэгтээ мөрдлөг болгон ажиллаж байна.

Тус газрын 2019 оны ээлжийн амралтын хуваарийн дагуу хяналтын улсын байцаагч П.Бороод ээлжийн амралтыг 08 дугаар сарын 08-ны өдрөөс 09 дүгээр сарын 04-ний өдрийг дуустал ажлын 20 өдрөөр, ахлах нягтлан бодогч Б.Тунгалагтуяад 08 дугаар сарын 16-ны өдрөөс 09 дүгээр сарын 10-ны өдрийг дуустал ажлын 18 өдрөөр, хяналтын улсын ахлах байцаагч С.Мөнх-Эрдэнэд 08 дугаар сарын 26-ны өдрөөс 09 дүгээр сарын 20-ны өдрийг дуустал ажлын 20 өдрөөр тус тус олгосон. Мэргэжилтэн Ш.Чулуун-Эрдэнэ нь байгууллагын даргын баталсан 2019 оны хилийн боомтод ажиллах ээлжийн хуваарийн дагуу 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн “Ханх” авто замын боомтод үүрэг гүйцэтгэж байна. Байгууллагын даргын 2019 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн Б/193 дугаар тушаалаар хяналтын улсын байцаагч О.Энхбаатар нь Хяналт шалгалтын газарт, 08 дугаар сарын 21-ний өдрийн Б/201 дүгээр тушаалаар хяналтын улсын байцаагч О.Хэрлэнг Дархан-Уул

аймаг дахь ахлах мэргэжилтнээр тус тус шилжүүлэн томилсон байна. Мөн байгууллагын даргын 08 дугаар сарын 12-ны өдрийн Б/199 дүгээр тушаалаар хяналтын улсын байцаагч Ж.Цэнд-Аюушд “Тайваны Багшийн Их Сургуулийн Мандарин хэлний төв”-д суралцах болсонтой холбогдуулан 08 дугаар сарын 20-ны өдрөөс 2020 оны 02 дугаар 20-ны өдрийг хүртэл 6 сарын хугацаатай суралцах чөлөөг олгосон байна.

ГУРАВ: Ирсэн явсан албан бичиг, өргөдөл гомдлын талаар

Тус газарт төвөөс болон бусад байгууллагаас нийт 16 албан бичиг ирснээс хариутай 5 албан бичгийн хариуг хугацаанд нь холбогдох байгууллагад хүргүүлж ажилласан.

Тайлант хугацаанд хугацаа хоцорсон болон шийдвэрлэх шатандаа явагдаж байгаа албан бичиг байхгүй болно. Тус газраас 7 албан бичиг бусад байгууллагад хандаж явуулсан байна.

Тайлант хугацаанд төрийн байгууллагын цахим хаягаар ирсэн 6 албан бичгийг холбогдох албан тушаалтанд танилцуулан, цахим мэдээний бүртгэлийн дэвтэрт бүртгэн ажилласан болно.

Тайлант хугацаанд тус газрын албан хаагчдаас чөлөө хүссэн 2 өргөдөл ирснийг газрын дарга танилцаж, шийдвэрлэж ажилласан.

ДӨРӨВ: Виз, бүртгэлийн талаар

Виз олголт:

Хойд бүс дэх газрын хэмжээнд 2019 оны 07 дугаар сарын 26-ны өдрөөс 08 дугаар сарын 25-ны өдрийн хооронд иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас гаргасан хүсэлтийн дагуу 25 орны 129 иргэнд зохих ангилал, зориулалтын визийг зохих зөвшөөрлөөр олгож ажиллаа. Үүнд:

Бельги-2, Австри-1, Азербайжан-2, Шри-Ланк-2, Грек-12, Литва-3, Македон-1, Польш-1, Филиппин-1, БНСУ-1, БНХАУ-12, Хорват-3, БНЭУ-2, Гүрж-1, Дани-2, ӨАБНУ-1, Иран-2, ИБУИНВУ-3, Ирланд-6, Испани-22, Канад-1, Лихтенштейны вант улс-1, Нидерланд-2, ОХУ-42, Португаль-4, Харьяалалгүй-2 иргэн байна. Олгосон визийг төрөл, зориулалтаар нь авч үзвэл: нэг удаагийн орох виз-114, нэг удаагийн гарах-орох виз-3, дамжин өнгөрөх виз-12 байна.

Визийн хураамж 10.188.000 төгрөгийг зохих төрийн сангийн дансанд төвлөрүүлэн ажилласан.

Хил орчмын зорчих үнэмлэхээр зорчигч иргэдийн хяналт

Хялбарчилсан журмаар хил орчмын нутагт зорчих үнэмлэхтэй ОХУ-ын 224 иргэнд бүртгэл хийсэн.

Түр ирэгчийн бүртгэл, хасалт:

Тайлант хугацаанд 8 орны 45 иргэнд бүртгэл, хасалт хийн, бүртгэлийн хураамж 81,000 төгрөгийг зохих төрийн сангийн дансанд төвлөрүүлсэн. Үүнд: АНУ-1, БНКаЗУ-1, БНХАУ-6, Иран-1, Израйль-4, Кыргыз-2, ОХУ-23, ХБНГУ-7 иргэн байна.

Оршин суух зөвшөөрөлтэй иргэдийн хасалт

Тайлант хугацаанд албан хүсэлтийн дагуу 3 орны 24 иргэний оршин суух үнэмлэхийг хураан авч, хасалт хийсэн байна. Үүнд: АНУ-15, БНКаЗУ-5, ОХУ-4 иргэн байна.

Алдаатай олгогдсон виз:

Тайлант хугацаанд Монгол Улсаас хилийн чанадад суугаа Элчин сайдын яам, Дипломат төлөөлөгчийн газар, Консулын газар, Өргөмжит консулаас алдаатай олгосон 7 орны 179 иргэний визийг хуулбарлан авч, шинээр виз олгосон байна. Үүнд: Австри-1, Польш-1, Унгар-1, БНХАУ-1, БНЭУ-2, Дани-2, Ирланд-1, Испани-24 иргэн байна.

ТАВ: Хяналт, шалгалтын талаар

Төлөвлөгөөт хяналт шалгалт:

Тус газар нь дарга 1, хяналтын улсын ахлах байцаагч 1, хяналтын улсын байцаагч 8, мэргэжилтэн 7 орон тоотойгоор ажиллаж байна.

Төлөвлөгөөт хяналт шалгалтын талаар: Төлөвлөгөөт-2 удаа /14/12, 14/13 зам гүүр чиглэлээр/-ийн удирдамжийн дагуу хяналт шалгалт явуулсан ба шалгалтад нийт 4 аж ахуйн нэгж, байгууллагын 59 гадаадын иргэн хамрагдсан. Шалгалтаар илэрсэн зөрчилгүй.

Төлөвлөгөөт бус хяналт шалгалтын талаар:

Сэлэнгэ аймгийн Цагдаагийн газрын 41/1-3014 дугаартай албан бичиг /утас:70369102/-аас Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Бугант тосгонд “Сэлэнгэ Эрдэнэ Вангийн Хошуу” нөхөрлөлийн талбайд байсан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэд Монгол Улсад зорчих, оршин суух, хөдөлмөрлөх эрхтэй холбоотой хууль тогтоомжийг зөрчсөн эсэхийг шалгаж хариу мэдэгдэнэ үү гэх Гомдол, мэдээлэлийг 2019 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн 14/37 тоот хяналт шалгалтын удирдамжийн дагуу Хойд бүс дэх газрын хяналтын улсын ахлах байцаагч С.Мөнх-Эрдэнэ, Сэлэнгэ аймгийн Тагнуулын газрын ажилтан Э.Ганбаярын хамт Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Бугант тосгонд “Өргөн Ерөө” “Сэлэнгэ Эрдэнэ Вангийн Хошуу” нөхөрлөлийн газар талбайд очиж, шалгахад БНХАУ-ын иргэд байгаагүй болно.

Холбоо мэдээллийн хэрэгслээр гомдол, мэдээлэл 2 ирсэн.

Монгол улсын иргэн Д.Эрдэнэчулуунаас /утас:95651074/ Сэлэнгэ аймгийн Ерөө сум, Бугант тосгоны урд БНХАУ-ын 5-н иргэн хууль бусаар алт ухаж байна. Эдгээр гадаадын иргэдийг ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулж байгаа эсэхийг шалгаж Монгол улсаас албадан гаргаж өгнө үү гэсэн гомдол мэдээллийн дагуу холбогдох ажиллагаа хийж, Гомдол мэдээллийн хүрээнд холбогдох материал, бичиг баримтыг шалгасан байдлыг үндэслэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт зааснаар гомдол мэдээлэл хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн.

Монгол улсын иргэн Л.Оюунгэрэлээс /99075287/ “Сайн байна уу. Facebook дээр БНХАУ-ын 3-н иргэн хууль бусаар алтны нинжа хийж, алт олборлон угааж байгаа тухай мэдээлэл явж байна. Та бүхэн хуулийн дагуу шалгаж шаардлагатай арга хэмжээг авч, нэн даруй таслан зогсоож өгхийг хүсч байна гэсэн гомдол мэдээллийн дагуу холбогдох ажиллагаа хийж, Гомдол мэдээллийн хүрээнд холбогдох материал, бичиг баримтыг шалгасан байдлыг үндэслэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт зааснаар гомдол мэдээлэл хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн.

Оногдуулсан торгох шийтгэлийн тухайд: Тайлангийн хугацаанд зөрчлийн хэрэг нээгээгүй. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд зааснаар 13 зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн байна.

Зөрчлийн тухай хуулиар зөрчил гаргасан 7 орны 30 иргэнд 2.140.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан. Үүнд: АНУ-1, Казакстан-1, Иран-1, Израйль-4, Кыргызын БНУ-4, ОХУ-14, ХБНГУ-7 иргэн байна.

Гадаадын иргэний урьсан 1 аж ахуй нэгж, байгуулагад 20.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ авч ажилласан.

Торгох шийтгэл оногдуулсныг хүснэгтээр үзүүлбэл:

Газрын нэр	Хувь хүнээр		Уригч байгууллагаар			Уригч хувь хүнээр		
	Иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч байгууллага	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ /төгрөг/	Уригч иргэн	Хамрагдсан иргэний тоо	Торгуулийн хэмжээ
ХБГ	29	2.120.000	1	1	20000	-	-	-
Хувь хүнээр 29 гадаадын иргэнд, уригч байгууллагаар 1 аж ахуйн нэгж, байгууллага /1 иргэн/-д Зөрчлийн тухай хуулийн дагуу торгох шийтгэл оногдуулж, нийт 2 сая 1 зуун 40 мянган /2.140.000/ төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн.								

Монгол Улсаас албадан гаргасан талаар: Тайлангийн хугацаанд албадан гаргасан иргэн байхгүй.

№	Улс	Зүйлчлэл				Нийт
		37.1.2	37.1.7	37.1.11	37.1.12	
1						
2						
БҮГД						

Хил нэвтрүүлэлгүй буцаасан иргэдийн талаар: Монгол Улсад орох визгүй болон хөрөнгийн эх үүсвэрийн баталгаагүй, ирсэн зорилго тодорхойгүй 6 орны 14 иргэнийг ГИЭЗБТХуулийн 22 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 145 дугаар тогтоолд тус тус заасны дагуу хил нэвтрүүлэлгүй буцааж ажилласан. Үүнд: Молдав-1, Узбекистан-1, Эстон-2, Гүрж-1, Кыргыз-8, ОХУ-1 иргэн байна.

ЗУРГАА: Мэдээлэл технологийн талаар

Тайлант хугацаанд газрын хэмжээнд нийт 6 дуудлага хүлээн авч, дуудлагын дагуу принтерийн программ болон word, office, ISM, зэрэг гэмтлүүдийг засварлаж ажилласан бөгөөд газрын даргын 14/38 дугаар удирдамжийн шалган зааварлах бүрэлдэхүүний хамт 08 дугаар сарын 12-ны өдрөөс 13 өдөр Архангай аймгийн төлөөлөл болон Дархан-уул аймгийн төлөөллийн техник, хэрэгслүүдийн программын гэмтлийг засаж, үйл ажиллагааг сайжруулж ажилласан.

ДОЛОО: Бусад ажлын талаар

Тус газрын 2019 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу газрын даргын 07 дугаар сарын 25-ны өдрийн 14/37 дугаар удирдамжаар 07 дугаар сарын 26-ны өдрөөс 31-ний өдрүүдэд ахлах нягтлан бодогч Б.Тунгалагтуяа, захиргааны мэргэжилтэн Г.Ариунзаяа, жолооч З.Баатархүү нар Хөвсгөл аймгийн “Ханх” авто замын боомтод үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчийн өдөр тутмын үйл ажиллагаа, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, ажлын байрны нөхцөлийг сайжруулах болон Ханх сум дахь ажилчдын байрладаг байшин, амьдрах орчинг судлан, засвар үйлчилгээ хийх шаардлагатай байгаа талаар танилцаж ажиллаа. Мөн 08 дугаар сарын 09-ний өдрийн 14/38 дугаар удирдамжаар 08 дугаар сарын 12, 13-ны өдрүүдэд Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Н.Ганболд, захиргааны мэргэжилтэн Г.Ариунзаяа, сүлжээний инженер Э.Наранбат нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Архангай аймаг дахь төлөөлөл ахлах мэргэжилтэн Б.Уламбаярын ажлын цаг ашиглалт, архив, албан хэрэг хөтлөлт, ажлын үр дүн, бүртгэл, хяналт шалгалт, эд хөрөнгө, үнэт цаасны ашиглалт, хамгаалалт зэрэг өдөр тутмын үйл ажиллагааг шалган зааварлах зорилгоор Архангай аймгийн Эрдэнэбулган суманд ажиллаа.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын орлогч Ж.Сайнцог даргын 08 дугаар сарын 19-ний өдрийн 1/636 дугаар албан бичгийн дагуу 08 дугаар сарын 21-ны өдөр “Худалдан авах ажиллагааг танилцуулах” улсын хэмжээний сургалтад тус газрын “Өмч хамгаалах байнгын зөвлөл”-ийн дарга Виз, зөвшөөрлийн ахлах мэргэжилтэн Н.Ганболд хамрагдаж, зөвлөгөө мэдээлэл авч ажиллаа.



